



**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 01/119

Улаанбаатар хот

**Б.Уртнасангийн хөдөлмөр эрхлэлтийн
харилцааг цуцлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.1.10, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.1.1, 78.1.4, 80.1.1 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 16 дугаар тогтоол, 9 дүгээр зөвшилцсон шийдвэр, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг, 9.9.8 дахь заалт, Амгалан дулааны станц ТӨХК-ийн Захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд 2021-2022 онд хэрэгжүүлэхээр байгуулсан Хамтын гэрээний 6 дугаар зүйлийн 6.21.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн хэмнэлтийн тухай хуульд төрийн өмчит компаниудад тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон тул Аж ахуй, хангамж эрхэлсэн Дэд захирал Батсуурийн Уртнасангийн хөдөлмөр эрхлэлтийн харилцааг 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөр дуусгавар болгон цуцалсугай.

2. Б.Уртнасангийн ажлыг хүлээлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:

Ө.Удвал

(Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч)

Гишүүд:

Н.Нэргүй

(Үндсэн хөрөнгийн нягтлан бодогч)

Т.Ичинхорлоо

(Хүний нөөцийн менежер)

3. Ажлыг 2022 оны 05 дугаар сарын 18-ны дотор актаар хүлээлцүүлж, баримтыг Захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлэхийг ажлын хэсэг (Ө.Удвал)-т үүрэг болгосугай.

4. Б.Уртнасанд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж тооцон олгохыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч (Ө.Удвал)-д зөвшөөрсүгэй.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Б.Ган-Очир)-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ш.БАЯНМӨНХ